

ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хэнтий аймгийн “Батширээт сум тохижилт” ОНӨААТҮГ 2021 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ХЭА-2022/13/НА-СТА-ОНӨААТҮГ

Цахим хуудас:
www.audit.mn

Чингис хот
2022 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Эрдэнэбаатар
Утас: 70562112

Аудитын менежер: Д.Оюунтуяа
Утас: 99775390

Аудитор: Б.Хуланхатан
Утас: 99008827

Цахим хаяг: khentii@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.Аудитын санал дүгнэлт	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан.....	6
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан.....	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....	9
3.1 Байгууллагын үйл ажиллагаа	9
3.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин	9
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого	9
Аудитын тайлан	11
4.1 Ерөнхий зүйл	11
4.2 Дотоод хяналт	11
4.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	11
4.4 Материаллаг байдал	11
5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	12
5.1 Шилэн дансны мэдээлэл.....	12
6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	12
7. Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	12
8. Аудитын илрүүлэлт	12
8.1 Залруулсан алдаа.....	13
8.2 Албан шаардлага.....	13
8.4 Зөвлөмж.....	13
9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	14
10. Аудитын тайлангийн хавсралт	15
10.1. Албан шаардлага	15

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

23119 Хэнтий аймаг, Хэрлэн сум, Сариг баг

Утас: 70-56-21-47, Факс: 70-56-21-12

E-mail: khentii@audit.gov.mn

2022.03.23 № 276

танай _____ -ны № _____ -т

Аудитын санал дүгнэлт гаргах тухай

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Хэнтий аймгийн Батширээт сум тохижилт ОНӨААТҮГ -ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгад аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Хэнтий аймгийн Батширээт сум тохижилт ОНӨААТҮГ -ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторов ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Байгууллагын эзэмшилд байгаа 5.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг тоолоогүй, үндсэн хөрөнгийн тайлан гаргаагүй зөрчил нь Нягтлан бодох бүртгэлийн тухай холбогдох заалтад нийцээгүй, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотроод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭРДЭНЭБААТАР

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайланг хугацаа: 2021.12.31

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	35.64	28,686.44
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	35.64	28,686.44
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	35.64	28,686.44
3121	Төгрөг	35.64	28,686.44
31213	Арилжааны банк дахь харилцах	35.64	28,686.44
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,195,333.33	1,479,750.00
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,195,333.33	1,479,750.00
392	Биет хөрөнгө	2,150,000.00	1,479,750.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	4,785,000.00	4,785,000.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(2,855,000.00)	(3,481,250.00)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	440,000.00	440,000.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(220,000.00)	(264,000.00)
39301	Програм хангамж	680,000.00	680,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(634,666.67)	(680,000.00)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,195,368.97	1,508,436.44
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	885,668.97	1,508,436.44
51	Засгийн газрын хувь оролцоо	885,668.97	1,508,436.44
512	Хуримтлагдсан үр дүн	885,668.97	1,508,436.44
51210	Өмнөх үеийн үр дүн	2,898,618.97	885,668.97
51220	Тайланг үеийн үр дүн	(2,012,950.00)	622,767.47
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	885,668.97	1,508,436.44

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

Тайланг хугацаа: 2021.12.31

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэ	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (1)	-	18,051,144.80
12	ТАТВАРЫН БҮС ОРЛОГО	-	18,051,144.80
120	Нийтлэг татварын бүс орлого	-	18,051,144.80
120010	Борлуулалтын орлого (цэвэр) /ТӨҮГ/		23,105,000.00
120011	Борлуулалтын өртөг /ТӨҮГ/		5,053,855.20
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,012,950.00	17,428,377.33
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,012,950.00	17,428,377.33
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,012,950.00	17,428,377.33
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,206,700.00	16,712,794.00
210811	Ерөнхий ба удирдлагын зардал /ТӨҮГ/	1,206,700.00	16,712,794.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	806,250.00	715,583.33
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	806,250.00	715,583.33
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(2,012,950.00)	622,767.47
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(2,012,950.00)	622,767.47

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2021.12.31

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	/төгрөгөөр/ /төгрөгөөр/ Засгийн газрын бусад хувь оролцооны нийт дүн	
					Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	2,898,618.97		2,898,618.97
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	2317144297 СНД0046 9074082	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	-		-
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-		-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-		-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-		-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	(2,012,950.00)		(2,012,950.00)
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-		-	
D01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	-	-	885,668.97	-	885,668.97
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-			
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	885,668.97	-	885,668.97
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-		-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-		-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-		-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-		-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	622,767.47		622,767.47
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	1,508,436.44	-	1,508,436.44

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайланг хугацаа: 2021.12.31

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)		23,105,000.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО		23,105,000.00
120	Нийтлэг татварын бус орлого		23,105,000.00
120013	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого /ТӨҮГ/		23,105,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	13,000.00	23,076,349.20
21	УРСГАЛ ЗАРДАЛ	13,000.00	23,076,349.20
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	13,000.00	23,076,349.20
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-	5,183,235.00
210106	Ажиллагчдад төлсөн /ТӨҮГ/		5,183,235.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	-	2,184,848.80
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/		2,184,848.80
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	13,000.00	15,708,265.40
210816	Татварын байгууллагад төлсөн /ТӨҮГ/		757,907.00
210818	Бусад мөнгөн зарлага /ТӨҮГ/	13,000.00	14,950,358.40
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	(13,000.00)	28,650.80
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	(13,000.00)	28,650.80
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	13,035.64	35.64
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	35.64	28,686.44

3. Санхүүгийн тайлангийн тодруулга

3.1 Байгууллагын үйл ажиллагаа

Хэнтий аймгийн “Батширээт сум тохижилт” ОНӨААТҮГ нь “Сумын тохижилт үйлчилгээний асуудлыг удирдан зохион байгуулах, хэрэгжүүлэх” гэсэн зорилготой ажиллаж байна. Батширээт сум тохижилт ОНӨААТҮГ-ын дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг нийтийн аж ахуйн чиглэлийн ажил үйлчилгээ, инженерийн шугам сүлжээний ашиглалт, хогны менежмент, бохир ус зайлуулах, авто замын засвар арчлалт, гүүрний арчлалт засвар хамгаалалт, гудамж талбайн тохижилт, гэрэлтүүлэг, хортон шавж устгал, ариутгал халдваргүйжүүлэлт, сумын төвийн ундны усны цэвэр усан хангамж, нийтийн болон ачаа тээвэр, бусад үйлчилгээг /байшин барилга, ажлын байр, зам талбай, газрын болон дундын өмчлөлийн эд хөрөнгө, машин, техник, тоног төхөөрөмж, ажил үйлчилгээний түрээс гэх мэт/ үзүүлнэ гэж тодорхойлжээ.

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар статустай байна.

3.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин

“Батширээт сум тохижилт” ОНӨААТҮГ нь Батширээт сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2014 оны 9 дугаар тогтоолыг үндэслэн байгуулсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлд. Орон нутгийн өмчийн талаархи иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын бүрэн эрх. 77.4-т “орон нутгийн өмчийн хуулийн этгээд байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах шийдвэр гаргаж, гүйцэтгэлд нь хяналт тавих” гэсэн заалттай нийцэж байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого

“Батширээт сум тохижилт” ОНӨААТҮГ тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.0	0.0	0.0
Авлага	-	-	-
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	-	-	-
Үндсэн хөрөнгө	2.2	1.5	(0.7)
Нөөцийн бараа	-	-	-
Нийт хөрөнгө	2.2	1.5	(0.7)
Өр төлбөр	1.3	-	(1.3)
Засгийн газрын оролцоо	-	-	-
Засгийн газрын оролцоо/Өмч - Төрийн/	-	-	-
Өмнөх үеийн үр дүн	2.9	0.9	(2.0)
Тайлант үеийн үр дүн	(2.0)	0.6	2.6
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	-	-	-
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	2.2	1.5	(0.7)

Банк дахь мөнгөний үлдэгдэлд арилжааны банк дахь харилцах дансанд байгаа 0.03 сая төгрөг байна.

Бараа материал дансанд 5.7 сая төгрөгийн аж ахуйн материал, 4.2 сая төгрөгийн түлш шатах тослох материалын орлого авч зарцуулсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэлд машин тоног төхөөрөмж /компьютер/ 4.8 сая, тавилга, эд хогшил 0.4 сая, программ хангамж 0.7 сая нийт 5.9 сая төгрөгийн хөрөнгө байна.

3.4. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Хэнтий аймгийн "Батширээт сум тохижилт" ОНӨААТҮГ байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

"Батширээт сум тохижилт" ОНӨААТҮГ нь 2021 онд эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг батлуулаагүй байна.

Гүйцэтгэлээр 18.0 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 17.4 сая төгрөгийн зардал гарган, 0.6 сая төгрөгийн ашигтай ажилласан байна.

Аудитын тайлан

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хэнтий аймгийн “Батширээт сум тохижилт” ОНӨААТҮГ -ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд аудит хийж аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгадагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Хуланхатан гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Оюунтуяа, дарга, тэргүүлэх аудитор Ч.Эрдэнэбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Хэнтий аймгийн “Батширээт сум тохижилт” ОНӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайланг Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 04 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Дотоод хяналт

“Батширээт сум тохижилт” ОНӨААТҮГ-ын удирдлага нь дотоод хяналтын үйл ажиллагааг зохион байгуулж хэрэгжүүлээгүй, нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг баталж мөрдөөгүй байна.

Хэнтий аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь дотоод аудитын чиг үүргийг хэрэгжүүлдэг ба “Батширээт сум тохижилт” ОНӨААТҮГ -ын 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд аудит гүйцэтгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудиторос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

4.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн аудитын зорилго оршино.

“Батширээт сум тохижилт” ОНӨААТҮГ -ын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

4.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 17.4 сая төгрөгөөс 1 хувиар буюу 0.2 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 0.1 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

5.1 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Шилэн дансанд мэдээлбэл зохих цалингаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 20.0 сая төгрөгийн 1, төсвийн гүйцэтгэлийг мэдээлээгүй, хагас жилийн санхүүгийн тайланг мэдээлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөвлөмж өгөх.

Өгсөн зөвлөмж : Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэн холбогдох мэдээллийг цаг хугацаанд нь бүрэн, үнэн зөв мэдээлж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 05 дугаар сарын 20 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайланд аудит хийгдээгүй байна.

7. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

8. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 25.9 сая төгрөгийн алдаа зөрчил илрүүлснээс, 5.9 сая төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 20.0 сая төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж өглөө.

Залруулагдаагүй 5.9 сая төгрөгийн алдаа зөрчил нь тогтоосон 0.1 сая төгрөгийн түвшнээс 5.8 сая төгрөгөөр их байгаа тул Хязгаарлалттай санал дүгнэлт өглөө.

8.1 Залруулсан алдаа

Санхүүгийн тайланд нягтлан бодох бүртгэлтэй холбоотой залруулга хийгдээгүй.

8.2 Албан шаардлага

Аудитаар 5.9 сая төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

1. Байгууллагын эзэмшилд байгаа 5.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг тоолоогүй, үндсэн хөрөнгийн тайлан гаргаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

8.4 Зөвлөмж

Аудитаар алдаа зөрчлийг арилгах 1 зөвлөмж хүргүүлээ. Үүнд:

1. “Батширээт сум тохижилт” ОНӨААТҮГ -ын дарга нь үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг гаргаж дүгнүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөвлөмж өгөх.

Өгсөн зөвлөмж : Жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан батлуулж, гүйцэтгэлийг тайлагнаж байх.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/																
д/д	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа зөрчлийн утга	Тогтоосон акт, албан шаардлага өгсөн зөвлөмжийн утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Запруулга		Акт		Үүнээс Албан шаардлага		Хариуцлага тооцох		Зөвлөмж	
					Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
Санхүүгийн тайлангийн асуудлаар																
1	Хэнтий аймгийн “Батширээт сум тохижилт” ОНӨААТҮГ	ХЭА-2022/13/НА-СТА-ОНӨААТҮГ	Байгууллагын эзэмшилд байгаа 5.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг тоолоогүй, үндсэн хөрөнгийн тайлан гаргаагүй.	Үндсэн хөрөнгийн тооллогыг хууль тогтоомжийн дагуу чанартай хийж, тооцоо бодож үлдэгдлийг баталгаажуулах, хөрөнгийн тайлан гаргах	1	5.9					1	5.9				
2	Хэнтий аймгийн “Батширээт сум тохижилт” ОНӨААТҮГ	ХЭА-2022/13/НА-СТА-ОНӨААТҮГ	Шилэн дансны сайтад мэдээлбэл зохих цалингаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 20.0 сая төгрөгийн 1, төсвийн гүйцэтгэлийг мэдээлээгүй, хагас жилийн санхүүгийн тайланг мэдээлээгүй.	Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэн холбогдох мэдээллийг цаг хугацаанд нь бүрэн, үнэн зөв мэдээлж байх.	1	20.0									1	20.0
3	Хэнтий аймгийн “Батширээт сум тохижилт” ОНӨААТҮГ	ХЭА-2022/13/НА-СТА-ОНӨААТҮГ	“Батширээт сум тохижилт” ОНӨААТҮГ -ын дарга нь үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг гаргаж дүгнүүлээгүй.	Жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан батлуулж, гүйцэтгэлийг тайлагнаж байх.	1										1	
Дүн					3	25.9					1	5.9			2	20.0



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 23

Дугаар 192/А 2370452
ХТХ - 2022/13/НА СТА-ТШБ

Чингис хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Батширээт сум тохижилт ОНӨААТҮГ -ын 2021 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Байгууллагын эзэмшилд байгаа 5.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг тоолоогүй, үндсэн хөрөнгийн тайлан гаргаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйл. "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого", 12.2-д "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ", 12.2.1-д "жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө", 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2022 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Батширээт сум тохижилт ОНӨААТҮГ -ын дарга Э.Энхболдод даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

Б.ХУЛАНХАТАН

Д.ОЮУНТУЯА

